



**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 01-ны өдөр

Дугаар 46

Булган сум


Төрийн шагналд уламжлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан “Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам”-ын 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Булган сумын 2 дугаар багийн иргэн Базарсад овогтой Мөнхжаргалыг “Алтан гадас” одонгоор шагнуулахаар багийн иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг, Булган сумын 5 дугаар багийн иргэн Пүрэвсүрэн овогтой Дамбыг Монгол улсын “Гавьяат механикжуулагч” цол, тэмдэгээр шагнуулахаар аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн саналыг тус тус дэмжсүгэй.

2. Төрийн шагналын тодорхойлолт, холбогдох материалыг аймгийн Засаг даргын Тамгын газарт уламжлахыг сумын Засаг дарга П.Нөхөрлөлбаярт даалгасугай.

ДАРГА



Б.ГАНЗОРИГ